

ДУНДГОВЬ АЙМГИЙН ИТХ, ЗДТГ-ЫН 2019 ОНЫ 6 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

“Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн ажлын явц болон хагас жилийн мэдээ тайлан, улсын архивын үзлэг, 3000 уртын дууч, морин хуурчдын “Уяхан замбуу тивийн наран” урлагийн их наадмын бэлтгэл ажил болон цаг үеийн байдлаар аймгийн 15 сумдтай цахим хурал зохион байгуулж, үүрэг чиглэл өглөө.

Засгийн газрын цахим хурлыг Боловсролын салбарын хөрөнгө оруулалт, элсэлтийн ерөнхий шалгалт сэдвээр цахим хурлын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгууллаа.

Багийн Засаг дарга нарын мотоциклын судалгаанд үндэслэн 10 багийн Засаг дарга, 5 сумын хэсгийн төлөөлөгчид 6 дугаар сарын 3-ний өдөр мотоцикл хүлээлгэн өглөө.

Сумдын баяр наадмын тов тогтоох тухай аймгийн Засаг даргын захирамжийг гаргаж сумдад хүргүүллээ. Засаг даргын зөвлөлийн 9, 10 дугаар хурлын бэлтгэл ажлыг ханган, Засаг даргын зөвлөлийн 22 асуудал, хэлэлцэн ЗГҮАХ-ийн 2019 оны төлөвлөгөөний хагас жилийн тайлан, Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн 2019 оны эхний хагас жилийн тайлан, “Бүтээн байгуулалт, иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн ажлын хагас жилийн хэрэгжилт, ӨГСХ-ийн 2019 оны хагас жилийн тайлан зэрэг асуудлыг хэлэлцсэн байна.

Монгол улсын ТАЗ-ийн дарга Баатарзоригоор ахлуулсан ажлын хэсэг аймагт ажиллаж төрийн захиргааны байгууллагын ахмадууд, хэлтэс, агентлагийн удирдлагуудтай уулзаж, 300 төрийн албан хаагчдад Төрийн албаны шинэ хууль, түүнтэй холбогдон гарсан дүрэм, журмуудын талаар сургалт зохион байгуулаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар зохион байгуулагдсан “Багийн Засаг дарга нарын манлайлал, ур чадвар” сэдэвт 2 өдрийн сургалтанд аймгийн 57 багийн Засаг дарга амжилттай оролцлоо.

ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ЗДТГ-ын нийт албан хаагчдад “Баримтжуулсан мэдээлэл, байгууллагын үйл явц тодорхойлох, Байгууллагын эрсдэл боломж тодорхойлох” сэдэвт сургалт зохион байгуулж, холбогдох даалгавруудыг өглөө. ЗДТГ-ын Чанарын удирдлагын хороо хуралдаж Байгууллагын Чанарын бодлого, зорилт, Хэрэглэгч, сонирхогч тал, байгууллагын гадаад дотоод орчны нарийвчилсан судалгаатай танилцаж байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалтыг баталлаа.

Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам, Төрийн захиргааны байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журмын төсөлд төрийн байгууллагуудаас санал авч нэгтгэн, Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудлууд түүнийг шийдвэрлэх талаарх саналыг боловсруулан Төрийн албаны зөвлөлд хүргүүллээ.

Төрийн байгуулалтын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийг сум байгууллагуудад дүгнэх аргачлал, үнэлгээний хуудсыг боловсруулж, бэлтгэн ажлын хэсгүүдэд хүргүүлэн, 15 сум 22 агентлагт урьдчилсан үзлэг шалгалтыг зохион байгуулж байна.

“Төрийн албан хаагчдын чадавхийг бэхжүүлэхэд ур чадварт шинжилгээ хийж, тасралтгүй суралцагч байгууллага болох нь” сэдэвт сургалтыг Мерит төслөөс зохион байгуулж, Засаг даргын Тамгын газрын ахлах мэргэжилтэн, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, газар, байгууллагуудын хүний нөөцийн ажилтан 34 албан хаагч хамрагдлаа.

“Бүтээн байгуулалт, иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд УИХ-ын гишүүн, Эдийн Засгийн байнгын хорооны дарга Д.Дамба-Очир, аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ, Засаг даргын орлогч Ж.Мөнхчулуун нар Сайнцагаан сумын 150 ортой 1-р цэцэрлэгийн барилга, Ахмадын өргөөний барилга, Сайнцагаан сумын 100 ортой нэгдсэн

эмнэлгийн барилга, аймгийн төвийн хатуу хучилттай 2,8 км авто замын шав тавих ёслолд оролцлоо.

Орон нутгийн удирдах ажилтны улсын зөвлөгөөнд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн өгсөн үүрэг, даалгаврын хагас жилийн хэрэгжилтийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв. Засгийн газрын тогтоол, шийдвэр, хуралдааны тэмдэглэлийг хяналтанд авч, Файлын санд ил тод байршуулав. Үүнд: Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай, 2019-2020 оныг Хүүхдийн хөгжил хамгааллын жил болгох тухай, Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр, 150 мянган айл- Орон сууц үндэсний хөтөлбөр зэргийг хяналтад авсан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 10 дугаар хуралдаан 2019 оны 7 дугаар сарын 1-ны өдөр болж 8 асуудлыг хэлэлцлээ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

№	Өглөг, авлага	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Үлдэгдэл
1	Өглөг	443,440,3	107,710,1	126,030,4	425,120,1
2	Авлага	276,237,1	121,948,5	11,999,6	386,186,0
Нийт		719,677,4	229,658,6	138,030,0	811,306,1

Төсвийн гүйцэтгэл

№	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	29,921,905,7	29,319,873,7	97,9%

Орлого

№	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
	11,758,805,3	13,178,150,5	112%

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хууль хяналтын үйл ажиллагаа: “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-д зориулан 16 удаагийн эрх зүйн албан бус сургалтыг Цахилгааны дамжуулах станцын хамт олонд Төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохион байгуулав. Аймгийн Засаг даргаас санаачлан хэрэгжүүлсэн “Авлигагүй шударга нийгмийн төлөө хамтдаа” уриалгыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, Цагдаагийн газраас хамтран насанд хүрэгчид болон хүүхдүүдийн дунд “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” эссэ бичлэг, “Авлигагүй ирээдүйн төлөө” гар зургийн уралдааныг тус тус зарлан дүгнэж, тэргүүлсэн иргэд, сурагчдыг шагнаж урамшуулах ажлыг ОУ-ын Хүүхдийн эрхийн хамгаалах өдрөөр зохион байгууллаа.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Авлигаас урьдчилан сэргийлэх тандалт судалгаа”-г “Оюуны гэгээ” ТББ-аар гүйцэтгүүлж, тайланг аймгийн Засаг даргын шуурхайд танилцуулан, зарим байгууллагууд тус ТББ-аас мэдээлэл авч, түүний мөрөөр үйл ажиллагаа зохион байгуулахаа илэрхийлсэн байна. Уг судалгааны тайланг www.dundgovi.gov.mn сайтны Ил тод байдал хэсгийн Авлигатай тэмцэх үйл ажиллагаа талбарт байршуулав. Авлигатай тэмцэх газрын 2019 оны зөвлөмжийн явцын хэрэгжилтэд ХШҮДАХ хяналт шинжилгээ-үнэлгээ хийж 84 хувийн гүйцэтгэлтэйгээр үнэлж, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэст хүргүүллээ.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн “Ашиг сонирхол харандаа”, “ХАСУМ”, “ХАСХОМ” харандаа зэрэг 3 төрлийн шторкийг сум, байгууллагуудад хүргүүлж, www.dundgovi.gov.mn сайт, Дундговь аймгийн ЗДТГ таныг сонсож байна пэйж хуудас, аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны сурталчилгааны самбар, ОБГ-ын гаднах ЛЕД дэлгэцүүдээр тус тус сурталчилж байна.

Аймгийн төвийн телекамерын хяналтыг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай хамтран телекамерт засвар үйлчилгээ хийж байна. Тус газрын “КРИМИНОЛОГИ СУДАЛГААНЫ БАГ” аймгийн хэмжээнд 2019 оны эхний хагас жилийн байдлаар гарсан гэмт хэрэг, зөрчлийн дүн мэдээнд

шинжилгээ хийж, цаашид зохион байгуулах ажил арга хэмжээг төлөвлөж, хариуцсан алба хаагч нарт үүрэг чиглэл тодорхой өглөө.

Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран сум бүрт 4 эрх зүйн хөтөч буюу аймгийн хэмжээнд нийт 60 “Эрх зүйн хөтөч”-ийг бэлтгэх эрх зүйн сургалтыг зохион байгуулж, гэрчилгээ олголоо.

Хүний эрхийн үндэсний комисстой хамтран “Хүний эрхийн нээлттэй өдөр” арга хэмжээг 2019 оны 6 дугаар сарын 19-20-ний өдрүүдэд зохион байгуулж, аймгийн удирдлага, иргэд, иргэний нийгмийн байгууллага, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад эрх зүйн сургалт, уулзалтуудыг зохион байгуулав.

Хуулийн байгууллагуудын “Хууль зүйн үйлчилгээг нэг цэгээс хүргэх нээлттэй хаалганы өдөр”-ийг 2019 оны 6 сарын 21-ний өдөр Мандал худалдааны төв талбайд аймгийн хуулийн байгууллагууд МУ-ын Хүний эрхийн үндэсний комисс, Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран зохион байгуулав.

2 дугаар улирлын сахилга хариуцлагын зөвлөгөөнийг 2019.06.19-нд сумдын хэсгийн алба хаагчид хариуцан зохион байгуулж “Алба хаагчдын хамтын ажиллагаа, ажлын хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга ёс зүйн зөрчилгүй ажиллая” уриалгыг гаргалаа. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Бяцхан зорчигч”, “Яараад яахав дээ” арга хэмжээнүүдийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж байна.

Нийтийн албанд түр хугацаагаар нэр дэвшиж буй Луус сумын Засаг даргын орлогч, СХЗХ-ийн ня-бо нарын Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв. Цагдаагийн газарт шинээр томилогдсон 4 алба хаагчтай тогтвортой ажиллах гэрээ байгуулж дадлагажуулагч томилон ажиллаж байна.

“Харилцаа хандлага сайжруулья” уриалгыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн ахмадын сургагч багш Ж.Эрхэмбаярыг урьж “Харилцаа хандлага өөрчлөх, хувь хүн өөрийгөө хөгжүүлэх” сэдвээр Цагдаагийн алба хаагчдад сургалт зохион байгууллаа.

Гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээлэл: Гэмт хэргийн шинжтэй 38 гомдол мэдээлэл бүртгэгдэж 12 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж, 22 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлж 33 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна. Зөрчлийн шинжтэй 78 гомдол бүртгэгдэж, Ердийн журмаар 470 иргэнийг 10.175.000 төгрөгөөр, хялбаршуулсан болон зөрчлийн хэрэг 13 нээж 54 иргэнийг 10.155.000 төгрөгөөр торгож, 8 жолоочийн эрхийг хассан байна.

Архивын ажлын мэдээлэл: Луус, Хулд, Өлзийт, Дэлгэрцогт, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн Төв номын сан, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Биеийн тамир спортын газар, Дундговь-Ус ОНӨҮГ, УЦУОШТ, БСУГ, Нэгдсэн эмнэлэг, Татварын хэлтэс, НДХ зэрэг 8 сум, 9 хэлтэс агентлагт Төрийн байгуулалтын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын урьдчилсан үзлэгийг удирдамж, хөтөлбөр, дүгнэх аргачлалын дагуу үнэлж дүгнэх ажлыг зохион байгууллаа

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Нийгмийн бодлогын хэлтэс: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хороог хуралдуулж Дундговь иргэний нийгмийн байгууллагын сүлжээ ТББ-аас хийсэн аймгийн жендэрийн тэгш байдлын талаарх нөхцөл байдлын үнэлгээг сонгож, салбар хорооноос хийх ажлын төлөвлөгөө, жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөрийн төслийг хэлэлцэн тэмдэглэлээр үүрэг чиглэл өглөө.

Говийн бүсийн ахмадын спортын наадам зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, тэмцээний удирдамжийг батлан, аймгийн Засаг даргаас 1 сая төгрөгний дэмжлэг үзүүлээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр төвийн болон баруун бүсийн сумдад сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган сумдад албан тоот хүргэж, сургалтын төлөвлөгөө, төсөв, бэлтгэл ажлын төлөвлөгөөг баталлаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аймгийн салбар зөвлөл, ХХҮГ, МСҮТөвтэй хамтран сумдын ХАБЭА-н салбар зөвлөлийн дарга, гишүүдийг чадавхжуулах сургалтыг Эрдэнэдалай, Сайнцагаан сумдад бүсчлэн зохион байгуулж 9 сумын 56 салбар зөвлөлийн гишүүдийг хамрууллаа. Сургалтын үеэр ОБГ, ЦТСС, НЭ, ААНБ-уудтай хамтран дадлага сургалтыг зохион байгууллаа.

Хүний эрхийн үндэсний комиссоос төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад Жендэр ба хүний эрх сэдвээр 1 өдрийг сургалтыг зохион байгуулж 10 байгууллагад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийн талаар шалгалт хийлээ. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд “START-UP” арга хэмжээний нээлт боллоо.

“Уяхан замбуу тивийн наран” урлагийн их наадмыг зохион байгуулах бүх салбар комиссын болон бүх сумдын бэлтгэл ажлын төлөвлөгөө, төсвийн тооцоо, “3000 уртын дуучид, морин хуурчид”-ын тоглолтод оролцох авьяастнуудын мэдүүлгийг дахин эцэслэн хүлээн авлаа. Наадмын бэлтгэл, зохион байгуулалтыг хангах, хамтран зохион байгуулах сумдын календарчилсан төлөвлөгөөг боловсрууллаа.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс: Таван толгойн нүүрс тээвэрлэлтийн “Эм Си Пи Эл” ХХК-тай хамтран 2019 оны 6 дугаар сарын 4-ны өдөр жолооч сонгон шалгаруулах ажлын ярилцлагыг зохион байгуулж уг компанид нийтдээ 23 иргэн анкет бөглөсөн бөгөөд шаардлага ханган ярилцлагад тэнцсэн 10 иргэнийг ажилд зуучиллаа.

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж тусламж хөнгөлөлтийн 6 дугаар сарын олголтод 3218 иргэний 336,1 сая төгрөгийн файл үүсгэж санхүүжилт олголоо. Хамтран ажиллах гэрээтэй Аясал ХХК-тай хамтран 6 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн хөгжлийн бэрхшээлтэй 11 хүүхдэд сэргээн засах үйлчилгээг үзүүлж байна.

Орон нутгийн 3 аж ахуйн нэгжийн 6 ажлын байр, Улаанбаатар хотын 4 аж ахуйн нэгжийн 15 ажлын байрны захиалгыг авч олон нийтийн телевиз болон байгууллагын веб сайтад мэдээллэж ажил хайгч иргэдийг бүртгэж байна. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 15-34 насны залуучууд, ажилгүй, ажил хийхэд бэлэн ажил идэвхтэй хайж байгаа залуучууд, их дээд сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын суралцагчид төгсөгчдөд аж ахуй, бизнес эрхлэх ур чадвар, шинэлэг санаанд тулгуурлан гарааны бизнесийг дэмжих “START-UP” арга хэмжээг “Монголын үндэсний маркетингийн холбоо” ТББ-тай хамтран зохион байгууллаа.

0-3 настай хүүхэдээ асарч буй эхийн “Цалинтай эх”-ийн тэтгэмжийн 6 дугаар сарын санхүүжилтэд 115,8 сая төгрөгийг арилжааны банкуудад хуваариллаа. “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн хүрээнд Өндөршил сумын зорилтод бүлгийн 30 иргэнд “Хөгжлийн хөтөч” ТББ-тай хамтран Хөдөлмөрт бэлтгэх сургалтын зохион байгуулж ажилласан байна.

Нийгмийн даатгалын хэлтэс: Аймгийн хэмжээнд Хөдөлмөрийн чадвар түр алдсаны /ХЧТА/-ын тэтгэмжийн эрх үүсэж байгаа 18 даатгуулагчдад, Жирэмсний болон амаржсаны /ЖБА/ Тэтгэмжийн эрх үүсэж байгаа 23 даатгуулагчдад, Оршуулгын тэтгэмжийн эрх үүсэж байгаа 3 даатгуулагчдад олгож, Ажилгүйдлийн тэтгэмж 1 иргэн шинээр тогтоолгож, ажилгүйдлийн тэтгэмжийг 14 иргэнд 3.2 сая төгрөг олгосон.

Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулиар 5 даатгуулагчдад зөвлөгөө өгсөн.

Ажилласан хугацаагаа тооцуулж, тэтгэвэр тогтоолгох талаар зөвлөгөө Monitoring программаас шүүсэн алдаатай 452 мэдээллийг шалгалаа.

2018 оны жилийн эцэст 37 ажил олгогчийн 34137.0 мянган төгрөгийн шимтгэлийн авлагын үлдэгдэлтэй гарсанаас 2019 оны 6 сарын 7-ны байдлаар 27 ажил олгогчийн 28.2 сая төгрөгийн авлага барагдуулаад байна.

Нийгмийн даатгалд хамрагдаж шимтгэл төлж байгаа 497 ажил олгогчийн 5741 албан журмын даатгуулагч, сайн дурын даатгалд 3998 даатгуулагч хамрагдаж шимтгэл төлж тооцоо хийсэн байна. Нийгмийн даатгалын санд 3,7 тэр бум орлого төлөвлөн 4,9 тэр бум төгрөгийн орлого оруулж 132,5 %-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

НДЕГ –ын даргын авлага барагдуулах 03 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах төлөвлөгөөт ажлыг шат дараалан хийж байна. Таван байгууллагын дарга удирдлагуудтай авлага барагдуулах талаар уулзалт зохион байгуулж, 3 ажил олгогчийн банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг өрөө төлж дуустал зогсоох улсын байцаагчийн албан мэдэгдэл хүргүүлж, 2 байгууллагад шимтгэлийн өрөө төлөх улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж ажилласнаар 2019 оны эхний үлдэгдэл 34,1 сая төгрөгийн шимтгэлийн авлагаас 27 ажил олгогчийн 28,7 сая төгрөг буюу 84,2%-ийг барагдуулсан байна.

Мөн 2019 оны 5 сарын 31-ний байдлаар нийт хянаж баталгаажуулсан ажил олгогчийн урсгал авлага 105,3 сая төгрөгийн авлага үүссэнээс өнөөдрийн байдлаар 34,2 саяыг барагдуулсан байна. Хэлтсийн даргын тушаалаар Нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны дунд хугацааны төсөөллийн саналыг боловсруулах, хяналт тавих ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Төсвийн төсөөллийг НДЕГ-ын даргын төсөв төсөөлөл боловсруулахад баримтлах зааврын дагуу нийгмийн даатгалын сан тус бүрээр орлого, зарлагын төрлөөр дэлгэрэнгүй байдлаар судалгаа тооцоололд үндэслэн боловсруулах ажлуудыг хийж байна.

Мөн 2019 оны 5 сарын 31-ний байдлаар нийт хянаж баталгаажуулсан ажил олгогчийн 105,3 сая төгрөгийн урсгал үүссэнээс өнөөдрийн байдлаар 92,3 саяыг барагдуулсан байна.

Эрүүл мэндийн газар: НҮБ-ын Хүн амын сан, Люксембургийн Их вант улсын санхүүжилттэй Эх, нярайн зайн оношлогооны төслийн 2017-2019 онд хэрэгжиж байгаа төгсгөлийн үе шатны үйл ажиллагаагааны хүрээнд Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт Эх барихын яаралтай тусламжийн сургалтын болон зайн оношлогооны шууд холболтын тоног төхөөрөмж нийлүүлэгдлээ. Мөн төрөх тасгийн эмч нарт Эх барихын яаралтай тусламжийн өртөөчилсөн сургалтын өрөөг байгуулж, ажлын байрны чадавхижуулах сургалт зохион байгууллаа. Мөн өсвөр үеийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдсан асуудлаар НҮБ-ийн ХАС-ийн мэргэжилтэнтэй ярилцлага хийлээ.

Төрөх тасагт 31 настай эхийн анхны төрөлтөөс жирэмсний тээлтийн 32 долоо хоногтойд яаралтай кесвэр хагалгаагаар амьсгал хямралын эмгэгтэй 1900 гр жинтэй төрсөн дутуу нярайд төрсний дараа сурфактант эмчилгээг амжилттай хийлээ. Сурфактант нь уушгины цулцангийн дотор ханын гадаргуугийн таталцлыг багасгаж, амьсгал гаргах үед цулцангууд наалдахаас сэргийлэх, уушгины уян чанарыг сайжруулах замаар хийн солилцоог хэвийн явуулах үүргэтэй гадаргуугийн идэвхит бодис юм. Энэ нь амьсгал хямралын хам шинжтэй 35 долоо хоногтойгоос доош тээлтийн хугацаанд төрсөн нярайд амьдралын эхний цагуудад сурфактант эмчилгээ хийгдэхэд эмчилгээний үр дүн нэмэгдэж дутуу төрсөн, бага жинтэй нярайн амьдрах чадварыг нэмэгдүүлж улмаар нас баралтыг бууруулах өндөр үр дүнтэй эмчилгээний арга юм. Уг эмчилгээ нь мэргэжлийн өндөр ур чадвар шаардсан багаар үзүүлдэг тусламж үйлчилгээ юм.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах сургалтанд оролцож томуу томуу төст өвчний дэгдэлтийн үеийн зохион байгуулалт, хариу арга хэмжээг орон нутагт хэрхэн зохицуулагдаж буй талаар ярилцлага хийгдлээ.

Нэгдсэн эмнэлэг бүтээн байгуулалтын жилийн ажлын хүрээнд байгууллагын хашаанд 127м төмөр хайс хийж, 200 суулгац тарилаа. Нэгдсэн эмнэлгийн ахмад настан жолооч Л.Лоомнанжид түүний гэр бүл ах дүү үр хүүхдүүд нь 300 ширхэг голт борын суулгац бэлэглэж суулгалаа.

ЗӨСҮТ-ийн "Тарваган тахал өвчний хариу арга хэмжээний бэлэн байдал" сэдэвт сургалт цахимаар зохион байгуулагдаж халдварт, яаралтай түргэн тусламж болон Зооноз өвчин судлалын төвийн мэргэжилтнүүд оролцлоо. Зоонозын өвчин судлалын төв нь Уламжлалт Анагаах ухааны төв, Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран "Зоонозын халдварт өвчний өнөөгийн байдал, оношилгоо, эмчилгээ халдварт өвчний үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ" сэдэвт сургалтыг Дэлгэрцогт, Гурвансайхан,

Баянжаргалан, Цагаандэлгэр, Өндөршил, Говь-Угтаал сум зэрэг Зүүн бүсийн сумдын Эрүүл мэндийн төвийн 58 эмч, эмнэлгийн ажилчдад сургалт зохион байгууллаа. Тус сургалтаар Зоонозын халдварт өвчний өнөөгийн байдал, байгалийн голомтын төлөв, мал, амьтны галзуу өвчний үед авах арга хэмээ, вакцинжуулалт, анзаарагддаггүй халдвар болох бэтэг, бруцеллёз өвчний эмнэл зүй, тархвар судлал, хариу арга хэмжээ, сэтгэлийн үйлийг зөв зохицуулан өвчнөөс сэргийлэх нь, хүч тамир сэлбэж, урт наслуулах уламжлалт ёс, эрүүл мэндийг дэмжих аргууд сэдвээр мэдээлэл хийлээ.

Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сарын аяныг “Антибиотикийг жорын дагуу хэрэглэе”, “Антибиотикийн даслаас урьдчилан сэргийлье” уриан дор зохион байгуулж тайланг нэгтгэн ЭМЯаманд хүргүүлэв. Эх хүүхдийн өвчлөл эндэгдлээс сэргийлэх зорилгоор ЭМГ-ын даргын тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Өлзийт, Луус, Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумдад эмэгтэйчүүд, хүүхэд, дотор, ЭХО-н эмч нар нөхөн үржихүйн насны болон 0-5 нас хүртэлх насны хүүхдэд үзлэг зохион байгуулж дотрын үзлэгт 446, хүүхэд 446, ЭХО 373, эмэгтэйчүүд 401 хамрагдаж 53 эмэгтэйг ЖСА-д хамруулав. Мөн эх хүүхдийн тусламж үйлчилгээнд хэрэгжиж байгаа тушаал шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийж арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

ДЭМБ-ын Номхон Далайн баруун бүсийн Захирал Такеши Касай Монгол улсад албан ёсны айлчлал хийж байгаатай холбогдуулан Дундговь аймагт ирж ажиллалаа. Уулзалтанд Дэд сайд Л.Бямбасүрэн, ДЭМБ-ын Монгол Улс дахь суурин төлөөлөгч Сергей Диордица, Эрүүл мэндийн яамны нийгмийн эрүүл мэндийн газрын дарга Энхзаяа, аймгийн удирдлагууд оролцлоо.

Ажлын айлчлалын үеэр “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд Мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх” төслийн нээлтэд оролцон, мобайль болон мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, урвалж оношилгуур зэрэг 30 гаруй тоног төхөөрөмжийг гардуулж өглөө. Төслийн онцлог тал нь Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны чиглэлүүдтэй нийцүүлэн, “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг баримтлан “ Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт”-ыг хэрэгжүүлж, “Хүн төвтэй цогц эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г ялангуяа, алслагдсан, төв, орон нутгийн эмзэг бүлгийн хүн амд гэрийн эргэлттэй хосолсон явуулын хэлбэрээр эх, хүүхдийн эрүүл мэнд, халдварт болон халдварт бус өвчний үзлэг, эрт илрүүлгийн мобайль технологи болон хурдавчилсан оношлуур, эмнэлгийн нэн шаардлагатай бусад тоног төхөөрөмж ашиглан тусламж үйлчилгээг үзүүлэх боломжтой болж байна.

Мөн Нэгдсэн эмнэлгийн удирдлагуудтай уулзалт хийн, аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцлаа. Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөр,Томуу томуу төст өвчний үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл солилцлоо. Зочдод зориулан “Бэсрэг наадам”-ыг зохион байгуулснаар монгол наадмын үүсэл, түүх, үндэсний ёс заншил, дэг жаягийг сурталчилан таниулсан арга хэмжээ болсон байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн захирал, доктор Такеши Касай ЭМЯ-ны харьяа байгууллагуудтай цахим хурал хийж Эрүүл мэндийн газар,Нэгдсэн эмнэлгийн удирдлагууд оролцлоо.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр"- ийг хэрэгжүүлэх хүрээнд тэмбүү өвчний тархалтыг хязгаарлан, улмаар устгах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Тэмбүүг устгая" үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд цахим сургалт хийгдэж "Тэмбүү өвчний эмнэлзүй, оношилгоо, эмчилгээ","Тэмбүү, ХДХВ-ийн халдвар илрүүлэх "Dual test"-ээр түргэвчилсэн сорил тавих арга аргачлал" сэдвээр мэдээлэл өгч аймгийн Эрүүл мэндийн газар Нэгдсэн эмнэлгийн холбогдох мэргэжилтнүүд оролцлоо.

Нэгдсэн эмнэлэг төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын урьдчилсан үзлэгээр 91%-тай шалгагдлаа.

Цагаандэлгэр сумын нутагт тарваган тахлын байгалийн голомт хяналтын тандал шинжилгээгээр 10 хоног ажиллаж, мэрэгч амьтдын зүйлийн бүрдэл, тархалт тоошлын судалгаа хийх, тарваган тахлын байгалийн голомтын төлөв байдлыг судлах зэрэг ажлуудыг

хийж гүйцэтгэлээ. Шинжилгээгээр 5 зүйлийн 91 мэрэгч олзворлож нян судлалын лабораторид шилжүүлээд байна. Шинжилгээний дүн гараагүй байна.

Дундговь аймгийн Хулд, Эрдэнэдалай, Дэрэн, Цагаандэлгэр сумдын боомын хамаарал бүхий цэгт газруудаас дээжилсэн сорьц материалд нян судлалын шинжилгээ хийхэд боомын үүсгэгч илрээгүй байна.

Боловсрол, соёл, урлагийн газар: Сурагчдын амралт эхлэхтэй холбогдуулан БСШУСЯ-наас ирүүлсэн удирдамж зөвлөмжийн дагуу сургууль бүр ахуйн болон зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, танихгүй хүнээс сэрэмжлэх зэрэг агуулгаар эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулж зөвлөмж хүргүүлээ.

Жайка олон улсын байгууллагын сайн дурын ажилтан Япон улсын иргэн Фүкүшима Мики 2017 оны 10 дугаар сараас хойш Дундговь аймагт байгалийн ухаан, бага ангийн багш нартай хамтран ажиллаад буцлаа.

Суурь боловсрол, Бүрэн дунд боловсролын үнэмлэх гэрчилгээний бичилтийн бэлтгэл ажил хийгдэж байна. БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг 12 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж боловсрол, соёлын салбарын ажилтнуудтай уулзалт зохион байгуулж БТА-аар 3, СТА-аар 3 багш ажилтнуудыг шагналаа. 10, 11-р ангийн анги дэвших шалгалтуудыг зохион байгуулж ажиллалаа.

Суурь боловсролын 653, бүрэн дунд боловсролын үнэмлэх 146 гэрчилгээний бичилтийг боловсролын удирдлагын мэдээллийн системд дүнг оруулж баталгаажилт хийж програмаас хэвлэж ажиллалаа.

Элсэлтийн ерөнхий шалгалтыг 17-20-ны өдрүүдэд зохион байгуулж 153 шалгуулагч 10 хичээлийн шалгалтад орж, Математик, Нийгмийн тухай мэдлэг хичээлээр 800 оноог Цэгцбилиг сургуулийн сурагчид авсан амжилт гарган ЭЕШ-ын дүнгээр улсад 6-д эрэмбэлэгдлээ.

ЕБСургуулиудын сургалтын менежер 2018-2019 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны тайлангаа хамгааллаа.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

ХХААГ, Сайнцагаан сумын ЗДТГ-тай хамтран хаврын тариалалттай холбогдуулан тариалан эрхлэгч иргэдтэй уулзан мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас олгож буй хөнгөлөлттэй зээл олгох зээлийн төсөлд нийт 45 аж ахуйн нэгж иргэнээс 4,3 турбум төгрөгийн төслийг бүртгэн хүлээн авч, зээлийн төсөл сонгон шалгаруулах дэд хороо хуралдаж ирсэн төслүүдийн анхан шатны бичиг баримтын бүрдлийг шалган ирсэн бүх төслүүдийг бүрдүүлбэл зохих материалын хамт программд шивж оруулах ажил хийгдэж байна.

Үлийн цагаан огтоно устгалын хяналтын ажлаар аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг Өндөршил, Баянжаргалан, Цагаан дэлгэр, Адаацаг, Дэрэн суманд ажиллаж 5 төрлийн малд төлөв байдлын үнэлгээг хийсэн. Үлийн цагаан оготнойтоой микробиологийн аргаар тэмцэх ажлаар нийт 10 суманд /Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Луус, Сайхан-Овоо, Сайнцагаан, Говь-Угтаал, Гурвансайхан/ зохион байгууллаа. ХХААГ-ын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг болон аймгийн мэргэжлийн хяналтын байцаагчийн бүрэлдэхүүнтэйгээр сумдад ажиллаж тайлан мэдээг хүлээн авч ажлын үр дүн гүйцэтгэлийн талаар малчидтай уулзаж санал хүсэлтийг хүлээн авч ажиллаа.

2019 онд 10 сумын 20 мян/га бэлчээрийн талбайд 40 тн бактержуулсан бэлдмэлийг цацах, технологи зааварчилга, хөдөлмөр, хамгаалалал аюулгүй ажиллагааны талаар УХЭШХүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд газар дээр нь ажиллаж зөвлөгөө өгсөн. Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх арга хэмжээг аймгийн ХХҮГазраас хэрэгжүүлдэг нийтийг хамарсан ажлын хүрээнд 100 иргэнийг түр ажлын байраар ханган хамтарч ажилласан байна.

Мал эмнэлгийн ариун цэвэр, халдваргүйтгэлийн сарын ажил зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын захирамж гарч сарын ажлыг 6 сарын 5-ны өдрөөс эхлүүлэн ажлын удирдамж, мал эмнэлгийн арга хэмжээний календарчилсан төлөвлөгөөг сумдад хүргүүлээд байна.

МЭГ-аас Дэлгэрцогт суманд зохион байгуулсан малчдын зөвлөгөөнд оролцож Мал амьтны эрүүл мэндийн хууль, мал эмнэлгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, Мал эмнэлгийн хүрээлэнгийн судлаачидтай хамтран Өлзийт суманд “ Ботгонд кокцидын эмгэгшүүлэх” шинжилгээ туршилтыг хийсэн.

Баруун болон төвийн бүсийн шүлхийтэй тэмцэх арга хэмжээг нэмэгдүүлэх төслийн хүрээнд нийлүүлэгдсэн оношлуур урвалж багаж тоног төхөөрөмжийг Улаанбаатар хотоос татан авчирсан.

Мал эмнэлгийн ерөнхий газрын хяналт эрсдлийн үнэлгээний газраас зохион байгуулсан аймгуудын мал эмнэлгийн байцаагч нарт зориулсан онлайн хуралд оролцлоо. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргатай цахим хурлаар дархлаажуулалтын ажлын чиглэл, албан даалгавар авлаа.

Шүлхийн өвчнөөс урьдчилан сэргийлэх 791400 тун вакцин хүлээн авсан. Мал эмнэлгийн сургуулийн багш нар ирж байгууллагын үйл ажиллагаа болон лабораторийн үйл ажиллагаатай танилцлаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны 6 дугаар сарын 19 өдрийн А/249 захирамж, Мал эмнэлгийн ерөнхий газраас гаргасан зураглал, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Адаацаг, Дэлгэрцогт, Сайнцагаан, Хулд, Луус сумын бог мал, үхэр, Дэрэн, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өндөршил, Гурвансайхан, Өлзийт, Сайхан-Овоо сумын үхрийг дархлаажуулах ажлыг 6 дугаар сарын 20-ны өдрөөс 14 хоногийн хугацаанд хийхээр ажиллаж байна. Шүлхийн дархлаажуулалтад хамрагдах сумдад вакциныг хуваарын дагуу олгож, сумдууд дархлаажуулах ажлыг эхлүүлээ. Гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний тандалт шинжилгээнд сорьц цуглуулахаар 2 ажлын хэсэг Адаацаг, Эрдэнэдалай, Луус, Дэлгэрхангай суманд ажиллаж 8 багийн 90 өрхийн 900 малаас сорьц цуглуулах ажилд аймгаас 4 малын эмч, 2 жолооч, тухайн сумдын тасгийн малын эмч нар ажиллалаа.

Сумын мал эмнэлгийн тасгийн байцаагч, тархвар зүйч нарын 2 өдрийн сургалт зохион байгуулж Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт, цаг үеийн ажил, байцаагчийн ёс зүй, зөрчил хянан шийдвэрлэх, баримт бичиг бүрдүүлэх талаар хичээл зааж, мал эмнэлгийн тасгийн ажилтнуудын хагас жилийн ажлыг дүгнэж, мэдээ тайлан гаргаж, тооцоо нийлсэн. Шүлхий дархлаажуулалтын ажил Сайнцагаан, Луус, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил суманд эхлэж 26,7%- тай таригдаж байна. Дэлгэрцогт, Хулд, Өлзийт, Адаацаг сумд эхлээгүй байна.

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр хэрэгжүүлэх нийт 21 төслийн саналыг “Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын систем”-д оруулан холбогдох яамд болон Сангийн яам руу хүргүүллээ.

Сум хөгжүүлэх сангийн улсын үзлэгийн дүнг нэгтгэн Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулан холбогдох материалыг ХХААХҮЯаманд хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын захирамжаар Гурвансайхан сумын бичил уурхайчдаас жонш худалдан авах 2 аж ахуйн нэгжийг дахин сонгож, захирамжийг суманд хүргүүллээ.

Швейцарын хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөлтэй хамтран ажиллах гэрээний дагуу Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй 5 сумын 30 бичил уурхайчдыг мэргэжлийн ур чадвар олгох богино хугацааны сургалтад хамруулах тухай гэрээ байгууллаа.

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Цагаандэлгэр сумын Сургуулийн албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр Анарзоне ХХК-ыг сонгон 2019 оны 6-р сарын 7-ны өдөр 30 сая төгрөгийн, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Луус сумын 80 хүүдийн дотуур байрны барилгын гүйцэтгэгчээр шалгарсан Ганцаг ХХК-тай 895,4 сая төгрөгийн, аймгийн төвийн хатуу хучилттай авто зам 2,8км /Сайнцагаан/-ын ажлыг гүйцэтгүүлэхээр тендерт шалгарсан Дэвших-Эрдэнэ ХХК-тай 2,176,017,018 төгрөгийн гэрээг тус тус байгуулсан.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийн төлөөлөлийг урьж харилцан туршлага солилцож, үйлдвэрлэлийн дэвшилтэт шинэ технологийн талаар суралцах замаар үйлдвэрлэл эрхлэгчдийн бодит орлого, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, хөгжүүлэх талаар санал бодлоо ярилцаж, үйлдвэрлэгчдийн харилцан хамтын ажиллагааны

эхлэлийг бий болгох зорилго бүхий үзэсгэлэн худалдаа зөвлөгөөнийг 2019.06.11-13-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Швейцарын хөгжлийн агентлагын Тогтвортой бичил уурхай төслийн хүрээнд аймгийн ЗДТГ-аас МСҮТ-тэй хамтран бичил уурхай бүхий Баянжаргалан, Гурвансайхан, Хулд, Луус, Өлзийт зэрэг 5 сумын 30 бичил уурхайчдыг мэргэжлийн ур чадвар олгох богино хугацааны сургалтад хамруулан энэ удаагийн сургалтыг “Тогооч”, “гагнуурчин” мэргэжлээр зохион байгуулж батламж гардууллаа.

Канадын Мерит төсөл, Дорнод их сургуулийн багш нартай хамтран “Уул уурхай амьдралын мөчлөг” сэдэвт сургалтыг Өлзийт, Дэлгэрхангай сумдад зохион байгууллаа.

“Торгоны зам” Олон Улсын Авторалли тэмцээнийг орон нутагт хүлээж авах, бэлтгэл ажлыг хангах хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дэд ажлын хэсгийн ажлын төлөвлөгөөг боловсрууллаа.

Сайхан-Овоо сумын “Төгрөг хайрхан уул”, “Харганы шугуй”-г аймгийн тусгай хамгаалалтад авах тухай асуудлыг Аймгийн ИТХ-ын Тэргүүлдэгчдийн хурлаар хэлэлцүүлээ.

Монгол орон даяар хэрэгжиж буй “Ногоон паспорт” аяны хүрээнд “Нэг удаагийн нийлэг хальсан уутнаас татгалзъя” видео уралдаан, “Байгалиа хамгаалъя” гэрэл зургийн уралдаанд амжилттай оролцсон Цэгц билиг сургуулийн эко клубын сурагчдад БОАЖСайдын “ТАЛАРХАЛ”, дурсгалын зүйлийг гардууллаа.

БОАЖЯам, Цэнгэг ус байгаль хамгаалах төвтэй хамтран НОГООН ПАСПОРТ-НОГООН ТӨГӨЛ” модлог ургамлын цуглуулгын цэцэрлэгт хүрээлэн байгуулах нээлтийн арга хэмжээг Гурвансайхан суманд болж БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга П.Цогтсайхан, Гурвансайхан сумын удирдлагууд, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сум дундын ойн ангийн төлөөлөл болон сумын ногоон байгууламжийн усалгаа арчилгаа хариуцсан ажилчид, сумын ерөнхий боловсролын сургуулийн ногоон паспорт эзэмшигч 130 гаруй сурагчдын төлөөллүүд хүрэлцэн ирж хамтдаа 3,5 га талбайг хашаажуулж 2000 гаруй мод, сөөг тарилаа.

Нью жуулчин турс, Баянбулаг жуулчны баазтай хамтран Бага газрын чулуунд олон улсын марафон гүйлтийн тэмцээнийг 6 сарын 14-16-ны өдрүүдэд зохион байгуулж тэмцээнд 140 гаруй гадаад, дотоодын тамирчид оролцож 2 төрлийн 60, 100 км-ийн бартаат замаар 3 өдрийн турш уралдаж дүнгээ гаргалаа.

Өмнөговь аймагт болсон “Ургамал оршихуйд-Амьдрал оршино” ургамлын говийн бүсийн эрдэм шинжилгээний бага хуралд асуудал хариуцсан мэргэжилтэн оролцлоо. БОАЖЯамнаас зохион байгуулсан “Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалт”-д амжилттай хамрагдсан 27 ААНэгжийн 130 иргэнд гэрчилгээг гардуулж байна.

ДОЛОО. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР

Хууль зүйн сайдтай байгуулсан гэрээний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ 75,7 хувь, Уул уурхайн сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилт 59,2 хувийн гүйцэтгэлтэй байна.

БТСГ, ЭМГ, МЭГ, ХХААГ, ОНӨГ, ГХБХБГ-уудад явцын хяналт шинжилгээ хийж зөвлөн туслах үйл ажиллагааг үргэлжлүүлэн ажиллалаа.

Авилгатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээ үнэлгээ хийж ХЭЗХ-т цаашид эрчимжүүлж ажиллах чиглэл, зөвлөмж өглөө.

Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, монгол улсын үндсэн чиглэлийн эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж байна.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн 10 дугаар хуралд ЗГХЭГ-аас аймгийн 2018 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоол шийдвэр, Бүтээн байгуулалт-Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн төлөвлөгөө зэрэгт хийсэн 2019 оны эхний хагас жилийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцүүлж, Хууль тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ЗГХЭГ-т хүргүүлээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяаны байгууллагуудын 2018 оны I-IV дүгээр улирлын Шилэн дансны мэдээлэлд хийх шалгалтыг дуусган шалгалтын танилцуулгыг бичиж Сангийн яаманд цахимаар хүргүүлээ.

Гурвансайхан, Өндөршил сумын төсвийн байгууллагуудад хийгдэх төлөвлөгөөт шалгалтын удирдамжийг цахимаар хүргүүлж ажилласан байна.

Өлзийт, Хулд, Луус сумын төсвийн болон ОНӨААТҮГ-уудад төлөвлөгөөт шалгалтыг гүйцэтгэж байна. Шалгагдсан байгууллагуудын шалгалтын материалыг нэгтгэн Дотоод аудитын хорооны хурлаар оруулах бэлтгэл ажлыг хангаж байна.

НАЙМ. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР

АДААЦАГ СУМ: Засаг даргын зөвлөлийн ээлжит хурлыг зохион байгуулж хурлаар 2018-2019 оны өвөлжилт хаваржилтын төлөвлөгөөний хэрэгжилт, СХСангийн зээлийн үйл явц, түүний хяналт, Хөдөлмөр эрхлэлт халамж хариуцсан мэргэжилтний ажлын тайлан, ахмадын хорооны ажлын тайлан, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зардал гаргах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

ДЭЛГЭРХАНГАЙ СУМ: Алдарт эхийн одон гардуулах, Дархан бэрд хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээг 5 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулж Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 88 дугаар зарлигаар “Алдар эхийн 2-р одон”-гоор шагнагдсан 6 ээжийн одонг гардуулж хүндэтгэл үзүүлэн сумын “Дархан бэрээр”: Жунай Насанжаргал, Пагам Түмэннасан, Ренчиндорж Ариунгэрэл, Магнайбаяр Урантуяа, Бум Хоролгарав ээжүүд өргөмжлөгдлөө.

ДЭЛГЭРЦОГТ СУМ: 2019 оны 6-р сарын 5-нд сумын “Малчдын зөвлөгөөн-2019”-ийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд нийт 91 малчин хамрагдаж, зөвлөгөөнөөр аймгийн Мал Эмнэлгийн газрын дарга Мөнхдүүрэн, ЭМГ, Улсын бүртгэл, ЗДТГ-ын мэргэжилтнүүд мэдээлэл хийж, сургалт явууллаа. Мөн Соёлын төвийн хамт олноос малчдад зориулсан урлагийн тоглолт, үдшийн цэнгүүнийг зохион байгуулж, жил бүр уламжлан зохион байгуулдаг “Унаган тамгатай дааганы уралдаан”-д 9 даага уралдлаа.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг болохтой холбогдуулан Төв комиссоос ирүүлсэн аргачлалыг төрийн байгууллагуудын удирдлага, архив хариуцсан ажилтнуудад ЗДТГ-ын дарга танилцуулж бэлтгэл ажил хангах үүрэг чиглэл өглөө. 2019.06.04-05-ны өдрүүдэд “Номгон хаш” ХХК-аас Ортопед тусгай хэрэгсэл нийлүүлж нийт 198 иргэнд 20.910.000 төгрөгийн үйлчилгээ үзүүлээ.

Сумын Цагдаагийн хэсгээс “Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай” хуулийн талаарх сургалтыг зохион байгуулж 28 хүн хамрагдлаа.

Сумын Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар Хүүхдийн цэцэрлэгийн эхний хагас жилийн тайлан, ГХУСЗ-ийн тайлан, Оготно устгалын тайлан, СӨГ-ын тайлан зэрэг асуудлыг хэлэлцлээ.

Төрийн албан хаагчдад Төрийн албаны тухай хууль, түүнтэй холбогдон шинээр гарсан журмууд, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн сургалтыг хийлээ. Үндэсний сур харваа болон шагайн харвааг хөгжүүлэх сумын дэд хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдийн дунд сургалт, сур харваа, шагайн харваан тэмцээн зохион байгуулж шилдгүүдээ тодрууллаа.

“Архидалтгүй Дундговь” дэд хөтөлбөрийн хүрээнд сургуулийн хүүхдүүдийн дунд “Архидалт ба хүчирхийлэл” гар зургийн уралдаан, “Архигүй аз жаргалтай гэр бүл” зохион бичлэгийн уралдааныг зохион байгууллаа.

Мөн хүүхдийн баяраар дугуйн уралдаан, зайрмагны баяр, плаш моб, дээсний тэмцээн, бөхийн барилдаан зэрэг уралдаан тэмцээнүүдийг амжилттай зохион байгууллаа.

2019.06.16-нд сумын тахилгат Эмтийн ширээ уулын тахилгат наадам болон жил бүр зохиогддог Хадаг наадмыг зохион байгуулж их нас 76, соёолон насны 72 морьд уралдлаа. Наадмаар уралдаанч хүүхэд, морьдыг бүртгэлийг хийж хамтарсан баг нь хүүхдийн хамгаалалтын хувцас, даатгал, эцэг эхийн зөвшөөрөлтэй эсэхийг шалгаж ажиллалаа.

ДЭРЭН СУМ: Аймгийн ИТХ-ын даргын нэрэмжит “Их нүүдэл” шатрын тэмцээнд манай сумаас 6 хүүхэд оролцсоноос Алт медаль -1, мөнгө медаль-2, хүрэл медаль-2 багийн дүнгээр 1-р байр эзэлсэн амжилтыг үзүүллээ. Сумын ИТХ-аас “Байгалиа хамгаалъя” сэдэвт гар зургийн уралдааныг ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгууллаа. Сумын 4 багийн БИНХ-ыг хуралдуулж 2020 онд ОНХС-аар хийх ажлын саналыг эрэмбэлэх ажлыг зохион байгуулах ажилд 300 гаруй иргэн оролцов.

МУ-ын Ерөнхийлөгчийн санаачлагаар хөрс хамгаалах өдрийг 5-р сард зохион байгуулж байхаар гаргасан шийдвэрийн дагуу улсын хэмжээнд хөрс хамгаалах өдрийг 2 дахь жилдээ орон нутагт зохион байгууллаа. Уг арга хэмжээг БОАЖЯам зохион байгуулж буй бөгөөд яамны мэргэжилтэн 5, хөрсний чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг 30 гаруй эрдэмтэн, докторууд, 4 сургуулийн 10 гаруй багш оюутан, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, БОАЖГ, ХХААГ, цаг уурын газар, сумын ЗДТГазрын албан хаагчид оролцож сумын хөрсний давхраг үе болон хөрснөөс дээж авч шинжилгээ хийлгэж байна.

Аймгийн ГБХЗХГ, Цагдаагийн газар, ЭМГ-аас “Хүүхдийн хөгжил, хамгаалал-2 аяны хүрээнд ЕБС-ийн 5-9-р ангийн 108 сурагч эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдан, ГБХЗХГ-ын сэтгэлзүйчтэй-1 гэр бүл, 3 сурагчтай уулзалт ярилцлага, ЕБС-ийн 6,7,8-р ангийн нийт 40 гаруй сурагчид цагдаагийн дэд хурандаа Ж.Жавзандулам-Цахим гэмт хэрэг, Охидын бэлгийн хүчирхийллийн талаар сургалтыг тус тус зохион байгуулсан.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 9-р хуралдаанаар: 1. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох тухай, 2. Газрын төлбөрийн суурь үнэ, итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээ тогтоох тухай, 3.Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгах саналыг хэлэлцэж дэмжиж тус бүр тогтоол гаргаж шийдвэрлэв.

Жил бүр уламжлал болгон явагддаг сумын Цант хайрханы тахилга наадам, Сүсэгтэн олны дунд Майдар эргэх ёслолыг Дэрэн сумын 8-н жилийн дунд сургуулийн 1, 2-р төгсөлтийн хамт олон зохион байгууллаа.

Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ээс цаг үеийн асуудлаар зохион байгуулсан цахим хуралд байгууллагын дарга, эрхлэгч нар, БЗД, ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн төлөөлөл оролцлоо.

Уяхан замбуу тивийн наран урлагийн их наадамд оролцох төрийн албан хаагчидтай сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга, ажлын хэсгийн гишүүд уулзалт ярицлагыг зохион байгуулж үүрэг чиглэл өгч ажилласан.

Улаанбаатар хотод Нутгийн удирдлагын ордонд зохион байгуулагдсан “Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах” сургалтад 4 багийн Засаг дарга хамрагдлаа. Монгол улсад хүн ам орон сууцны тооллого явуулахтай холбогдуулан өрхүүдийн бүртгэл 68,1 хувьтай байна.

ЛУУС СУМ: Цагаан-Овоо уулын тахилга наадмыг зохион байгуулж их нас 38, даага 17 уралдаж хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллалаа.

“ХҮҮХЭД ГЭР БҮЛДЭЭ АЗ ЖАРГАЛТАЙ” хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж 5-9 ангиудын дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгууллаа. 2019.05.31-нд сумын хүүхдийн баярын арга хэмжээ удирдамжийн дагуу зохион байгуулагдлаа. Улсын МХЕГ-ын шалгалт, Сум хөгжүүлэх сан, ОНХС-ийн улсын үзлэг тус суманд хуваарийн дагуу ажиллалаа.

ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, ХШҮ хийх чиглэлээр ТАХ-д, иргэдэд сургалт зохион байгуулагдаж 40 гаруй хүн хамрагдлаа.

2019 оны 6 сарын байдлаар төсөл сан, төсвийн байгууллагууд 560,106,500 мянган төгрөгийн санхүүжилт авч, 553,939,500 мянган төгрөгийн зарлага, 12,138,700 мянган төгрөгний өглөгтэй гарсан.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргаж санхүүгийн самбарт байршуулан, өглөг, авлагын мэдээг фри баланс програмд, Төсөвт байгууллагууд, эм эргэлтийн сангийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг шивж, шилэн дансны мэдээллийг сар бүр, тухай бүрийн мэдээ оруулан баталгаажуулсан. Dundgovi.gov.mn-д төсөв санхүүтэй холбогдолтой мэдээ мэдээлэл төсвийн гүйцэтгэлийн мэдээний нэгтгэлийг байршуулсан аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн ерөнхий нягтлан С.Энхжаргал СХСангийн улсын үзлэг, төрийн сангийн дотоод хяналт шалгалт хийж зөвлөн туслалж ажиллаа. Багийн засаг дарга нар 6 дугаар сарын 3-7-ны өдрүүдэд хагас жилийн малын түүвэр тооллогоор Нийт 66 малчин, мал бүхий өрхөд ажилласан.

Сумын нутагт дэвсгэрт 2019 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 17 цагийн орчмоос хүртэл байгалийн онц аюулт үзэгдэл угалз шороон шуурга мөн бороо, мөндөр орж албан байгууллага, болон айл өрхүүдэд нэлээд хохирол учрууллаа. - Шороон шуурганы үеэр 4 цаг тог тасарсан

- Нийт 13 малчин өрхийн гэр , воганчиг, үүдний амбаар унаж эвдрэн, машины цонх хагарсан
- ЗДТГ-ын өргөтгөлийн дээврийн хар цаас хуурч 60% нь урагдсан
- Сумын төвийн айл өрхийн хашааны 80% орчим нь ямар нэг хэмжээгээр нурсан
- Сургуулийн дотуур байрны үүдний тамбарын нэг талын дээвэр хуурч унасан
- Төвийн худгийн дээвэр хуурч унасан
- Релейны шугамын шон -2ш сууриараа ойчсон
- Холбооны шугам -1 хугарсан
- Төрийн албан хаагчдын орон сууцны дээврийн шифр их хэмжээгээр хагарч унан хучлагагүй болсон учир 6 дугаар сарын 4-нд сумын онцгой комисс шуурхай хуралдан ЗД-ын орлогчоор ахлуулсан групп гарч газар дээр нь үзэж эрсдлийн үнэлгээ тогтоогоод байна.

Байгууллагуудаас хагас жилийн тайлан мэдээнүүдийг авч нэгтгэн холбогдох газруудад хүргүүлж байна.

Уяхан замбуу тивийн наран 3000 уртын дуу, морин хуурчдын наадамд оролцоход зохион байгуулах ажлын төлөвлөгөө,наадамд зарцуулагдах зардлын тооцоог НБХэлтэст хүргүүллээ.

2019 оны 6 дугаар сарын 12-нд Наран багийн малчин Г.Энх-Амгалангийн мал худгийн усаа голоод уухгүй байна гэсэн дуудлага ирсний дагуу усны дээж авч, шинжилгээ хийлгүүлэхээр Мэргэжлийн хяналтын газарт хүргүүллээ.

Сумын хэмжээнд мах хадгалах зориулалттай агуулахын судалгаа, 2018 онд шинээр гаргасан худгийн судалгааг ХХААГазарт хүргүүллээ.

СХСангийн хяналтын зөвлөлийн хамт хөдөөд ажиллан, төсөл хэрэгжүүлж буй зээлдэгчдийн үйл ажиллагааг шалган энэ оны 6 дугаар сарын 1-ээс СХСангийн зээлийн мэдээлэл Монгол банкны зээлийн мэдээллийн санд орж эхлэх болсонтой холбоотой мэдэгдлийг хүргэлээ.

2019 онд Бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцсэн ажлын тайланг хийж дуусгасан ба СХСангийн улсын үзлэгтэй холбоотой тайлан судалгаануудыг гаргасан.

Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд аудит хийх явцад илэрсэн зээлийн хугацаа хэтэрсэн 2 зээлдэгчийн 1 960 772 төгрөгийн зөрчлийг бүрэн барагдууллаа.

ӨЛЗИЙТ СУМ: “Бүтээн байгуулалт, Иргэн төвтэй төрийн үйлчилгээ”-ий жилийн ажлын зорилтын хүрээнд нэгдсэн өдөрлөгийг зохион байгуулахаар төлөвлөсөн хөтөлбөрийн дагуу “Багуудын нэгдсэн өдөрлөг” арга хэмжээг 2019 оны 5 дугаар сарын 24-нд зохион байгуулж нийт 326 малчин иргэд ирж оролцлоо.

Уламжлал болгон жил бүрийн хаврын нөр их ажлын дараа малчдаа сумын төвд урьж шинээр гарч буй хууль, журам танилцуулах, сумын ЗДТГ-аас хийж бүтээж буй ажил, төрийн бусад үйлчилгээг нэг цэгээс хүргэх, иргэдээ сонсож СӨГ хүлээн авч шийдвэрлэх, малчин иргэдийн дунд уралдаан тэмцээн явуулах, эрүүл мэндийн болон урлаг соёлын үйлчилгээг цогцоор үзүүлэх ажлыг зохион байгууллаа. Энэ удаагийн өдөрлөгт аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Төв халхын дуулалт бүжгийн театрын хамт олныг урьж оролцуулан, сумын Эрүүл мэндийн төв “Нээлттэй үйлчилгээ” үзүүлж ард иргэдэд үйлчиллээ. Өдөрлөгийн үеэр “Бидний цөөхөн Монголчууд” төслийн баг бүрэлдэхүүн зураг авалт, ярилцлага хийж бидний явуулж буй үйл ажиллагааг өргөн дэлгэр сурталчилж өглөө.

2019 оны өмчийн бүх хэвшлийн мал, тэжээвэр амьтдыг бүрэн хамруулахаар малын түүвэр тооллогын ажлын хэсгийг сумын Засаг даргын 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн

А/73 дугаар захирамжаар томиллоо. Тус тооллогын хүрээнд сумын хэмжээнд сонгогдсон 116 малчин өрхийн малын түүвэр тооллогын ажлыг зохион байгуулсан.

ӨНДӨРШИЛ СУМ: Өндөршил сумын хүүхэд хамгааллын хамтарсан баг, ЗДТГ, Цагдаагийн хэсэг хамтран 2019 оны 6 сарын 1-нд нийт хүүхдүүдийн дунд дугуйн уралдааныг амжилттай зохион байгуулсан.

Зуны дунд сарын шинийн 8-ны билэгт сайн өдөр "Шилийн зоо уулын" тахилга баяр наадамд 37 хурдан соёлон насны морь уралдаж, 32 бөх барилдаж Өндөршил сумын харъяат Аймгийн арслан Х.Батбаяр түрүүлж, үзүүрт Сумын заан Б.Ууганбаатар их шөвөгт сумын заан Б.Болор-Эрдэнэ залуу бөх М.Эрдэнэ-Отгон нар шалгарлаа.

Зүүн бүсийн эмч, эмнэлгийн ажилчдын дунд зохион байгуулсан Зоонозын халдварт өвчний өнөөгийн байдал, оношлогоо эмчилгээ, халдварт өвчний үеийн бэлэн байдал хариу арга хэмжээ" сэдэвт сургалтанд 11 хүн хамрагдсан.

Төгсөх 9-р ангийн сурагчид ангийнхаа нийт ширээ сандлыг лакдаж, сургуулийн гадаа цэцгийн мандалд тоосгоор хашаа барьж өглөө.

Эх үрсийн баярт зориулсан "Бяцхан мисс, би жентельмен" уралдаан зохион байгуулж нийт 35 хүүхэд оролцлоо мөн шилдэг гэр бүлийг тодруулан алдаршууллаа. Соёлын ажилчид болон ардын авьяастан МУСТА Н.Жаргалсайхан ардын авьяастан С.Энх-Амгалан болон дугуйлангийн сурагчид нартай хамтран ЭЭЖИЙН БҮҮВЭЙТЭЙ ХОРВОО уран бүтээлийн тоглолт зохион байгууллаа.

САЙНЦАГААН СУМ: "Тогтвортой амжиргаа 3" тай хамтран хөдөөгийн 4 багийн 350 гаруй иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, ОНХСангийн төлөвлөлтөнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, санал авах арга хэмжээ, өдөрлөгийг зохион байгууллаа.

Уг арга хэмжээнд аймаг, сумын удирдлагууд оролцон цаг үеийн мэдээлэл болон 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, хэрэгжүүлж байгаа ажлын талаар мэдээллэн, иргдээс санал авлаа.

Өдөрлөгт оролцсон малчдад ЭХО, Дотор, Мэдрэлийн эмч нар эрүүл мэндийн үзлэг, өмгөөлөгчдийн холбооны салбараас хууль, эрх зүйн зөвлөгөөг үнэ төлбөргүй хүргэж, Дуурьсал хамтлаг ая дуугаа өргөлөө.

Төвийн 5 багийн ИНХуралд 311 иргэн хамрагдан ОНХСангаар 2020 онд хийх ажилд санал өгч, "Захиргааны ерөнхий хууль", Албадан эмчилгээнд явуулах талаар", "Хог хаягдлын тухай хууль", "Зөрчлийн тухай хууль"-ийн талаар мэдээлэл авсан байна

Мерит төслийн багтай хамтран сумын ЗДТГ-ын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт боловсруулж холлбогдох газарт хүргүүлээ. Хөтөлбөрийн дагуу "Төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх зорилгоор ур чадварт шинжилгээ хийж, тасралтгүй суралцагч байгууллага болох нь" сургалтанд 33 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авлаа. Сумын харъяа төсөвт 15 байгууллагын нийт 2287ш төлбөрийн хүсэлтээр 6,034,705.9 мянган төгрөгийн гүйлгээ шивэж хянан баталгаажуулж дамжууллаа.

Орон нутгийн татварын орлого 5 сарын мэдээгээр 185.5 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 202.5 сая төгрөг буюу 103.7 хувийн биелэлттэй байна.

Төсөвт байгууллагуудын 6 сарын санхүүжилтийг хуваарийн дагуу хөтөлбөр зориулалт бүрээр хянаж хуваарилж олголоо. Аймгаас авах санхүүгийн дэмжлэг 24.9 сая төгрөгөөр бүрэн төвлөрүүллээ.

БСУГ-ын даргын А/24 тушаалаар тус сумын сургууль, цэцэрлэгийн хамран сургах тойрог шинэчлэгдэн батлагдлаа. 2019-2020 оны хичээлийн жилд ЕБ-ын 4 сургуулийн 6 настны ангид 368 хүүхэд, СӨБ-ын 8 цэцэрлэгт 1562 хүүхэд хамрагдах судалгааг гаргалаа.

Сумын засаг даргын А/136 тоот захирамжаар сумын харъяалалтай 15 бүтэн өнчин хүүхдэд Төрийн банк, Цоглог ертөнц ХХК-тай хамтран хүндэтгэл үзүүлж, 300000 төгрөг зарцууллаа.

Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Дугуйн уралдааныг Хас банктай хамтран 6 насны ангиллаар зохион байгуулж, 120 гаруй хүүхэд оролцлоо. Нийт 18 хүүхдийг Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа.

Сумын Засаг даргын А/64 тоот захирамжаар Засаг даргын орлогчоор ахлуулсан Уяхан замбуу тивийн наран урлагийн наадам зохион байгуулах ажлын хэсэг хуралдаж аймгаас ирсэн хяналтын тооны дагуу байгууллага, багуудад хувааж, Морин хуур-250, уртын дуу-1020 нийт 1270 иргэн оролцохоор боллоо.

Төрийн үйлчилгээний албан хаагчдын дунд Төрийн албан хаагчийн ёс зүй, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Харилцаа сэдвүүдээр сургалт зохион байгуулж, байгууллагын удирдлагын талаарх сэтгэл ханамжийн судалгаа авч, 74 албан хаагч оролцлоо.

Амьдрах чадвар олгох 4 модуль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн сургалт ГБХЗХГазрын “А” танхимд боллоо. Сургалтыг 7 сэдвийн хүрээнд сургуулийн нийгмийн ажилтнууд болон “Оюуны гэгээ” ТББайгууллага, нийгмийн бодлогын мэргэжилтэн, багийн нийгмийн ажилтнууд хамтран зохион байгуулж, “Аз жаргалтай иргэн” дэд хөтөлбөрийн 59 иргэн хамрагдлаа.

Сумын ЭМТөв: Цэгц билиг, ЭДЦСургуулийн эмч, Насан туршийн боловсролын багштай хамтран дунд бүлгийн 60 сурагчид, ЭДЦС-ийн 1, 2-р дотуур байрны 103 хүүхдэд НҮЭМ-ийн цогц сургалтыг зохион байгууллаа.

МУ-ын ЗГ-ын 255-р тогтоол “Эрүүл хүүхэд-Эрүүл шүд” үндэсний хөтөлбөрийн танилцуулан, хөтөлбөрийн хүрээнд харъяа 1, 6-р цэцэрлэг, Хүмүүнлэг сургуулийн 2-6 настай 290 буюу нийт хүүхдийн 76.5 хувьд амны хөндийн эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, эрүүл ахуйн дадал олгох сургалт зохион байгууллаа.

“Сайнцагаан хонины омог” батлуулах хаврын хянан магадлагааны ажлын ХХААЯам болон аймгийн ХХААГ-ын бүрэлдэхүүнээс гадна сумын удирдлагууд, ЗДТГ-ын бие бүрэлдэхүүн, албан хаагчид, цэргийн дүйцүүлэх албаны 6 албан хаагч, хамрагдсан малчин өрхүүд идэвхитэй, санаачлагатай оролцлоо.

Нарлаг багийн 14 дүгээр байрны гадна фасадны ажлын тендерийн үнэлгээний хороо хуралдаж “Нийтийн жишиг орон сууцны гадна тохижилтын ажлын” гүйцэтгэгчээр “Ерөө констракшн” ХХК компанийг сонгон шалгаруулж захиалагчид хүргүүллээ.

Бүрд рестораны уулзварын 4ш гэрлийн шонг шинэчиллээ./агаарын 6000кваттын кабельд хуучин шонгууд ойр байсан тул солих шаардлагатай байсан./Мандлын 15-р гудамжны гэрэлтүүлгийн 32 шон суурилуулж асаалаа.

Нийтийн хамарсан ажлын хүрээнд 1-р ээлжинд хамрагдсан 6 ажилчин 23м³ хог хаягдлыг түүж, засмал замын шороог шүүрдэж 43м³ шороог ачуулж, 7-р багийн нийтийн эзэмшлийн талбай, орон сууц байгууллагуудын орчин тойрны хогийг 2 удаа бүрэн цэвэрлэлээ.

Сумын “Тэжээлийн агуулах барих ажил”-ын тендерийг ажлын 5 хоногоор зарлан шаардлага хангасан тендер ирээгүй тул шууд гэрээ байгууллахаар дүгнэлт гарган хүлээлгэн өглөө.

Үйзэн багийн нутаг “Амар булаг” гэх газар зөвшөөрөлгүй жонш ухах гэж байна гэсэн дуудлагын дагуу байгаль орчны хяналтын улсын байцаагч, багийн дарга, Хэсгийн цагдаа, нар шалгалт хийж, албан шаардлага өглөө

Түгээмэл тархацтай ашигт малтмалын татварын орлого 7.910.000 төгрөг төвлөрүүллээ.

САЙХАН-ОВОО СУМ: Төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар шинэчлэн боловсруулж, төрийн албан хаагч анкет 05 дугаар тоотой шинэчилэн янзласан.

Эрүүл мэндийн төв нь иргэн төвтэй орчинг бий болгон засвар үйлчилгээ, зам, гэрэлтүүлэг хийж, “Эерэг хандлага “сургалтанд эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдан ирж, сургалтыг хийлээ. “Төрийн албаны ёс зүй” сэдвээр 18 эмч, мэргэжилтэн ажилчдад сургалт зохион байгууллаа.

Соёлын төвөөс “Ээжүүдээ алдаршуулья”, “Дархан бэр”, “Уран бэр”, “Хослон дуулж ханилан жаргая” гэр бүлийн тоглолтыг зохион байгуулж 150 гаруй хүн оролцлоо.

Морин хуур, Уртын дууны сургалт цагийн хуваарийн дагуу эхлээд явагдаж байна. Уртын дуунд- 37, морин хуурт-20 хүн хичээллэж “Уяхан замбуу тивийн нар”, “Энх мэндийн баяр”, “Эр бор харцага” Зээргэнтийн шил дуунууд, Морин хуурын 4 аялгуу тус тус зааж сургалаа.

Энэ сард номын сангаар 89 хүн үйлчлүүлсэн байна. Нийт олгосон номын тоо 95. Үүнээс зөврөөр 28, гэрээр 67 ном хэвлэлээр үйлчилгээ үзүүлсэн байна. 565 ном программын тооллогонд оруулсан. Монгол төрийн бичгийг дээдлэн дэлгэрүүлж сурталчилан таниулах үндэсний хэл бичгээрээ бахархах, сурах идэвх сонирхлыг нэмэгдүүлэх, хөхиүлэн дэмжих зорилгоор жил бүр Үндэсний бичиг үсгийн баярыг сурагчдын дунд Хурдан уншигч, Хичээнгүй бичигтэн, Эртний сургаалийн зохиолоор ном бүтээх, Мэдлэг чадварын сорилго, Минутын уншлага зэрэг 5 төрлөөр зохион байгууллаа. Мөн “Хөдөөгийн амьдрал” сэдэвт гар зургийн уралдаанд 49 сурагч оролцлоо. 2018-2019 оны хичээлийн жилийн эцсийн тайланг Дундговь аймгийн Боловсрол Соёл урлагийн газарт цэцэрлэгийн эрхлэгч, аргазүйч нар хийж, хэрэгжүүлсэн ажлаа тайлагналаа.

ХУЛД СУМ: Засаг даргын зөвлөлийн хурал 2019.06.03-ны өдөр хуралдаж Сумын баяр наадмын тов товлох, Сумын төвийн төвлөрсөн халаалт тавих санал ирүүлсэн “Бэсүжин трейд” ХХК-ы саналыг хэлэлцэн зохих шийдвэрүүд гаргав. Сумын нэгдсэн халаалтын талаар Барилга хөгжлийн төвөөс хамгийн сайн хийгдсэн сумын зураг төсөв техникийн нөхцлийг авч халаалт тавих саналтай компаниудад хүргүүлж нээлттэй сонгон шалгаруулалт хийх, сумын баяр наадмын сумын тахилгат Хулд уулын тахилгатай хамтатган зохион байгуулахаар болов.

2011-2018 оны Сум хөгжүүлэх сан, ОНХсангийн үйл ажиллагааны хэрэгжилт, санхүүгийн баримт бичигт улсын үзлэгийн ажлын хэсэг ирж шалгалт хийсэн.

Хагас жилийн ажлын тайлан мэдээг гаргах ажлын хүрээнд хууль болон тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бүтээн байгуулалт иргэн төвтэй үйлчилгээний жилийн төлөвлөгөөний биелэлт, аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтүүдийн биелэлтийг гаргаж нэгтгэн дүгнэж аймагт хүргүүлээд байна. 2019.06.03-ны өдөр болсон хүчтэй шороон шуурганы улмаас иргэдэд учирсан хохиролын судалгааг багуудаас гарган нэгтгэж Олдох, Шувуутай багийн иргэдийн хохиролын талаар сумын ӨХЗөвлөл, үнэлгээний комиссын дүгнэлт, цаг уурын байгууллагын тодорхойлолт, дэмжлэг хүссэн албан тоотоор 5,6 сая төгрөгний хохирол барагдуулж өгөх хүсэлт аймгийн ОБГазарт хүргүүлсэн.

Төрийн албаны хуулийн дагуу төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сул 2 орон тооны судалгаа, холбогдох материалыг бүрдүүлэн аймагт ТАСЗ-д хүргүүлэв.

ЦАГААНДЭЛГЭР: Сумын засаг даргын Тамгын газраас ард иргэдэд төрийн үйлчилгээг зохих хууль дүрмийн дагуу үзүүлж ЗДТГ-ын аппарат 7 хоног бүрийн 1 дэх өдрүүдэд шуурхай цуглааныг хийж өнгөрсөн 7 хоногт хийгдсэн ажлын биелэлт, гарч буй 7 хоногт хийгдэх ажлуудын талаар мэдээллийг хэлэлцэж ирлээ. Мөн албан байгууллагын дарга, эрхлэгч нарын хурлыг 7 хоног бүрийн 5 дах өдөр хийж байгууллага дээрээ хийсэн ажлын биелэлт, дараа 7 хоногт хийх ажлын талаар мэдээллийг хэлэлцэж байна. 6-р сарын 12, 13-ны өдрүүдэд Дундговь аймаг, ӨМӨЗО-ы Баяннуур аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтарсан, үзэсгэлэн худалдаанд оролцож, аймаг, орон нутгийн эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг нэмэгдүүлэн, хөгжүүлэх талаар ярилцаж бараа бүтээгдэхүүнээ сурталчиллаа.

Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд энэ сарын 11-14-ний өдрүүдэд Улаанбаатар хотод болсон Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулж буй “Манлайлал, ур чадвар” сэдэвт сургалтад хамрагдлаа. 2019.06.12-ны мэдээллийн цагаар Засаг даргын Тамгын газрын дарга З.Солонго Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан ЗГ-ын 38-р тогтоолоор баталсан жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, ЗГ-ын 9-р тогтоолоор баталсан “ТЖАХ-ийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”, 8-р тогтоолоор баталсан “Албан үүргээ гүйцэтгэх явцад ТАХ-ийн амь нас хохирсон тохиолдолд ар гэрт нь нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”, 7-р тогтоолоор баталсан “ТАХ-д өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”, 6-р тогтоолоор баталсан “ТАХ-д нөхөх төлбөр олгох журам”-уудын шаардлагатай хэсгүүдээс мэдээлэл хийлээ.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Ашиг сонирхолын зөрчлийн талаарх шторкийг албан хаагчдад хүргэлээ.

ЗДТГ-ын дарга З.Солонго, Санхүү албаны дарга Ё.Мядагмаа нар Цагаандэлгэр сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний батлагдсан зургийг танилцууллаа. “Бүтээн байгуулалт- Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн ажлын хүрээнд төрийн үйлчилгээг хөдөөгийн иргэдэд түргэн шуурхай бодитойгоор хүргэж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх зорилгоор ЗДТГ-аас санаачлан ИТХ, төсвийн байгууллагуудтай хамтран ИТХ-ын дарга, Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг хөдөөгийн 3, төвийн 1 нийт 4 багт “ХҮЛЭЭЖ БИШ ХҮРЧ ҮЙЛЧИЛБЭ” төрийн үйлчилгээний өдөрлөгийг 2019.06.07-нд Жаргалан багт, 06.08-нд Замын улаан багт, 06.10-нд Хараат, Дэлгэрэх зам багуудад амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгөөр төсвийн байгууллагууд болон төрийн албан хаагчид 2019 оны хагас жилийн үйл ажиллагааны товч тайлан, иргэд ялангуяа малчдад холбогдолтой шинэчлэн гарсан хууль тогтоомжоор мэдээлэл хийж гарын авлага материал тараан асуусан асуултанд хариулж ажиллалаа.

Сумын ИТХ-ын дарга Т.Түмэндэлгэр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр охид болон бага насны хүүхдийн хүчирхийлэл, байгаль орчинд хор хөнөөлтэй шил, хуванцар сав зэрэг байгальд тэсвэртэй хог хаягдлыг хэрхэн ангилах хаях талаар малчид, малчдын бүлгүүдтэй хэрхэн хамтарч ажиллах талаар мөн Улаан загалмайн хорооны үйл ажиллагааны талаар мэдээлэл хийлээ.

Засаг дарга Д.Буджав 2019 онд улсын төсвийн болон аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд, сумын баяр наадам, Говьсүмбэр аймагт болох Боржигон наадмын тухай, 2019.08.09-11-нд Их газрын чулуунд болох “Уяхан замбуу тивийн наран” 3000 морин хуур, уртын дуучдын урлагын их наадмын талаарх мэдээллийг өгч уг наадамд хэрхэн оролцох мөн тус урлагын наадмын бэлтгэл ажил болгон 2019.06.18-19-нд зохион байгуулах “Авъяаслаг Боржигончууд” сумын урлаг спортын бага наадмын удирдамж чиглэлийг танилцууллаа.

ЭМТ-өөс 118 иргэнд эрүүл мэндийн үзлэг хийж, зөвлөгөө өгч эмийн сангийн үйлчилгээ, Цагдаагийн хэсгээс 2019 оны гэмт хэрэг зөрчил, тэдгээрийн шийдвэрлэлт талаар танилцуулга хийж иргэдтэй уулзаж, ЕБС-ийн насан туршийн боловсролын багш Н.Оюунцэцэг “Бүх нийтийн боловсролыг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд хийгдэж байгаа багуудын дунд зарласан болзолт уралдааны удирдамжын талаар болон “Санхүүгийн боловсрол” сургалт, Хүүхдийн цэцэрлэгээс малчид, иргэдийг тогтвортой оролцох боломжоо хангаж явуулын цэцэрлэг ажиллуулж хүүхэд харах үйлчилгээг үзүүлж 38 хүүхэд хамрагдлаа. Соёлын төвөөс явуулын номын сангийн үйлчилгээ 36 иргэнд, ургийн бичиг хөтлөлтийн дэвтэрийг 24 өрхөд, уртын дууны сургалтыг 18 хүнд явуулж өдөрлөгийн үйл ажиллагааны төгсгөлд урлагын тоглолтоор бэлэг барьж үдшийн цэнгүүн зохион байгууллаа. Энэхүү өдөрлөгийн үйл ажиллагаанд нийт 4 багийн 251 иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж ажилласан байна.

ЭРДЭНЭДАЛАЙ СУМ: Хүүхэд хөгжил хамгаалал аяны хүрээнд ГБХЗХГ, аймгийн нэгдсэн эмнэлэг, Цагдаагийн газраас хамтран тус суманд аян зохион байгуулж, сумын хамтарсан багт арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж, зорилтот 18 өрхийн гишүүд болон байгууллагуудын эцэг эхийн зөвлөлд зөвлөн туслаж, 5-12 ангийн 642 хүүхдэд үзлэг хийж 210 хүүхдэд мэргэжил сонголт сэдвээр сургалт хийн ажиллаа.

2019.05.19-ний өдөр "Хоггүй орчин-эрүүл амьдрал" уриан дор 7-р багийн Засаг дарга Ж.Өлзийжаргал, Байгаль орчны мэргэжилтэн Эрдэнэзаяа нар хүнсний талон авдаг 38 иргэнийг хамруулан нийтийн эзэмшлийн талбайг 4 хэсэгт хувааж цэвэрлэх ажлыг 14 хоног тутам, тогтмол хийж хэвшүүлэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2019 оны 5 дугаар сарын 9-ны өдрийн А/43 тоот захирамжаар “Байгалиа хамгаалъя” аяны хүрээнд 2019.05.24-ний өдрийн 14-18 цагийн хооронд сумын хэмжээний бүх нийтийн цэвэрлэгээг хийлээ.

Сумын иргэдтэй уулзалт зохион байгуулж Засаг дарга С.Мөнхбаатар цаг үеийн ажил, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын талаар мэдээлэл хийлээ уулзалтад багийн Иргэдийн нийтийн хурлын дарга ЗДТГ-ын мэргэжилтнүүд оролцлоо,.

ОУ-н хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Зайрмагны баяр-2019" арга хэмжээ, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, дугуйн уралдаан, "Архигүй аз жаргалтай гэр бүл" эссэ бичлэгийн уралдаан, "Архидалт ба хүчирхийлэл" гар зургийн уралдааныг ЗДТГ болон ААН,

хувиара бизнес эрхлэгчид хамтран зохион байгуулж амжилттай оролцсон хүүхдүүдэд шагналыг гардууллаа.

Засаг Дарга С.Мөнхбаатар 22 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс сумын төвд байгаа 7 хүүхдэд гэрээр нь очиж, хөдөө байгаа хүүхдүүдэд Багийн Засаг Дарга нараар нь дамжуулан баярын бэлэг хүргүүлээ.

Баярын арга хэмжээний хүрээнд "Алдарт эхийн 1-р одонгоор 1 хүн, 2-р одонгоор 30 эх шагнагдсан бөгөөд дархан бэрийн одонгоор 19, Уран бэрийн одонгоор 1 эмэгтэй тус тус шагнагдлаа.

ИТХ-ын ээлжит X хурал 2019.06.06 өдөр болж Сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилт, Сумын газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, Зарим газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох, эсэх, Сумын 2019 оны төсөвт өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг хэлэлцэн баталлаа.

Аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлөөс баруун бүсийн сумдын ХАБЭА-н зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах сургалтыг 2019 оны 06 сарын 17-18-ны хооронд Дундговь аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн багш нар, мөн аймгийн ХХҮГазрын хөдөлмөрийн хэлтэсийн дарга Цэвэлмаа нар 2 хоногийн сургалт зохион байгуулан сургалтанд 4 сумын ХАБЭА-н салбар зөвлөлийн 33 хүн хамрагдлаа.

Сумын ЭМТ-өөс "ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН СУРГАГЧ БАГШ", цусны донорын дэлхийн эрүүл мэндийн өдрийг тохиолдуулан "АЮУЛГҮЙ ЦУС ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮН ХЭНД Ч ХААНА Ч" уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх сэдэвт сургалтуудыг амжилттай зохион байгууллаа.

Тусламж үйлчилгээний чиглэлээр өглөө бүр жижүүрийн сувилагчаас мэдээллийг авч, тусламж үйлчилгээ болон цэвэрлэгээ үйлчилгээ, эмнэлгийн дотоод журмын мөрдөлтөнд хяналт тавьж ажиллаж байна. Нийт эмч ажилчдыг эмэгтэйчүүд, дотрын эмчийн үзлэг оношилгоонд 90 % -тай хамруулсан байна.

2019 оны 6 дугаар сарын байдлаар 433 үзлэг, хүнд урьдчилан сэргийлэх 167 үзлэг хийгдсэн байна.

ЗДТГ-н ХАА-н тасгийн МАА-н төлөвлөлт менежмент, малын үржил бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн нь 2019.06.01-18 ны хооронд ХАА-н холбогдол бүхий мэдээ мэдээлэл, тоон үзүүлэлтүүдийг гаргаж, холбогдох газруудад шаардлагатай материал, мэдээ тайланг хүргүүлж ажиллалаа.

Аймгийн ЗДТГ-с зохион байгуулсан цахим хуралд сумын ЗДТГ-ын албан хаагчид оролцон АЗДҮАХөтөлбөрийн хэрэгжилт, цаг үеийн ажлын талаарх мэдээллийг авч санал бодлоо солилцлоо.

Сумын хэмжээнд малын 71,7% нь төллөж, ботго 184, унага 1867, тугал, 1018, хурга 100335, ишиг 75434 бойжиж байна.Төлийн хорогдол хурга 166, ишиг 267, унага 1-н хорогдолтой байна. Малын генетик нөөцийн тухай хууль болон өсвөр хээлтүүлэгч сонгох гарын авлага, МИД-н гарын авлага сонин зэргийг малчдад өгч ажиллаж байна.